

10-Р АНГИЙН ТҮҮХИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**2024.06.05**

Нэр:

анги бүлэг

Хугацаа: 60 минут

Нийт оноо: 100

1. Ховд аймгийн Манхан сумын нутагт орших Хойд Цэнхэрийн агуйн хадны зураг нь өвөг түүхийн аль үед хамаарах вэ?

А. Палеолит Б. Мезолит В. Неолит Г. Энеолит

2. Тохирох ойлголтыг нөхөж бичнэ үү? \ олзворлох аж ахуйн үе, нүүдэллэн, хуучин

.....чулуун зэвсгийн үед хүн байгаль дээр байгаа зэрлэг ан амьтан, загас, идэш болохоор үр жимс ус хайн нэг газраас нөгөөд байнга.....амьдарч байв. Ийм маягаар ан агнах, загасчлахыг..... гэнэ.

3.Модун шаньюйн дараа хэн хаан ширээнд суусан бэ?

А. Түмэн шаньюй Б. Лаошан шаньюй В. Гүнчэн шаньюй Г. Гаоди

4. Хүннү, Хан улсууд “Энх ургийн гэрээ”г хэдэн онд байгуулсан бэ?

А. НТӨ 209 онд Б. НТӨ 221 онд В. НТӨ 198 онд Г. НТӨ176 онд

5. Хабул хааны дараа хаан ор суусан Амбагай ямар овгийн хүн бэ?

А. Тайчууд Б. Хонгирад В. Урианхай Г. Боржигон

6. Ямар аймгийн толгойлогчид “Хурганы үс гуужив, төлөгний үс төлжив” хэмээн довтлон ирж Тэмүжинийг олзолсон бэ?

А. Мэргэд Б. Татар В. Тайчууд Г. Найман

7. Тамирын Шар ордонд болсон их хуралдайгаар хэнийг хаан ширээнд өргөмжилсөн бэ?

А. Мөнх Б.Гүюг В. Хубилай Г: Өгөдэй

8. Монголчууп хэдэн онд нийслэл Дайду хотыг Хятадын Мин улсад алдсан бэ?

А. 1268 Б. 1368 В. 1378 Г. 1388

9. Улт төрийн нэгдмэл байдлыг сэргээх оролдлогыг хийсэн хаан хэн бэ?

А. Хубилай Б. Тогоонтөмөр В. Эсэн тайш Г. Төгстөмөр

10. Түмэдийн Алтан хан Монголд ямар шашныг дэлгэрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн бэ?

А. Шарын шашин Б. Бөөгийн шашин В. Христийн шашин Г. Лалын шашин

11. Эдгээрээс аль нь дунд чулуун зэвсгийн үеийн ололт вэ?

- А. Нум сум зохион бүтээсэн
- Б. Хадны зураг зурж эхэлсэн.
- В. Хэл яриа үүссэн.
- Г. Үйлдвэрлэх аж ахуйд шилжсэн.

12. Нөхөж бичээрэй.

Неолитын төгсгөл үед хүмүүсийн хийсэн технологийн нээлт ньхэмээх төмөрлөг байлаа.

13. Хүний түүхэн дэхь томоохон ололт нь гал гаргаж сурсан явдал байв. Галыг хүний ямар төрөл анх гаргаж сурсан бэ?

- A. Хомо хабилис
- B. Хомо эректус
- C. Хомо неандерталь
- D. Хомо сапиенс

14. Жужан улсыг мөхсөний дараа Монгол нутагт ямар угсааны улсууд ноёрхох болсон бэ?

- A. Түрэг угсааны
- B. Монгол угсааны
- C. Хятад угсааны
- D. АБ хариулт зөв

15. Хүннү гүрэн цэрэг засаг захиргааны ямар зохион байгуулалттай байсан бэ?

- A. Аравтын\Аравт, зуут, мянгат, түмт\ зохион байгуулалт
- B. Аймаг хошуу сумын зохион байгуулалт
- C. Мужийн зохион байгуулалт
- D. Аймаг ,овог, хот айл ,өрх айлын зохион байгуулалт

16. Цагадайн улсын захиргаанд ямар ямар улс багтаж байсан бэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. Монгол Төвд, Солонгос, Хятад
- B. Иран, Ирак, Азйрбайджан,Гүрж, Турк, Афганистаны баруун хэсэг,Сирийн хэсэг
- C. Дорно зүгт Эрчис мөрөн, өрнө зүгт Дунай мөрний доод урсгал,Өмнө зүгт Ижил мөрөн
- D. Казакстан болон Шинжааны ихэнх нутаг Узбек. Тажик Киргиз

17. Алтан ордны улсыг бие даасан улсын хэмжээнд хүргэсэн хаан хэн бэ?

- A. Зүчи
- B. Кебек
- C. Газан
- D. Бат

18. Монгол улс төрийн хямрал болоход нөлөөлсөн гол шалтгаан юу вэ?

- A. Эдийн засаг нийгмийн тогтворгүй байдал
- B. Монголын хаадын алдаатай бодлого
- C. Шарын шашин дэлгэрсэн нь
- D. Хааны хүч суларч, ноёдын бие даах эрмэлзэл ихэссэн

19. Данзанравжаагийн бүтээлд аль нь багтахгүй вэ?

- A. Урьхан хонгор салхи
- B. Саран хөхөөний тууж
- C. Үлэмжийн чанар

20.Нөхөж бичээрэй.

.....бодлого гэдэг нь монголчуудын цэрэглэх чавдарыг бууруулах, сүргийн бүтцийг алдагдуулах, , өөрсдийн аюулгүй байдлыг хамгаалах, хүчээ зузаатгахад чиглэсэн бодлого байв.

21. Чулуун зэвсгийн хөгжлийн үеийг хологдох он цагтай нь зөв холбоно уу?

- | | |
|-----------------------|------------------|
| 1. Палеолитын доод үе | А. 12000-8000 |
| 2. Палеолитын дунд үе | Б. 100000-40000 |
| 3. Палеолитын дээд үе | В. 40000-120000 |
| 4. Мезолитын үе | Г. 800000-100000 |

- | | | | |
|-------------------|-------------------|-------------------|-------------------|
| 1. 1Г, 2Б, 3В, 4А | 2. 1Б, 2А, 3Г, 4В | 3. 1В, 2Б, 3Г, 4А | 4. 1А, 2Б, 3Г, 4В |
|-------------------|-------------------|-------------------|-------------------|

22.



- А. Хуурай болон шингэн зүйл хадгалах боломжтой ус чийг нэвтэрдэггүй
- Б. Амьтны яс байгалийн чулууг ашигласан гоёл чимэглэлийн зориулалттай

В. Уналга ачлаганд хэрэглэдэг зүйл

Г. 3 хөлт цөгцөн ёроолт гэж 2 хувааж үздэг

- | | | | |
|-------------------|-------------------|-------------------|-------------------|
| 1. 1Г, 2Б, 3А, 4В | 2. 1Б, 2Г, 3А, 4В | 3. 1А, 2Г, 3В, 4Б | 4. 1В, 2А, 3Г, 4Б |
|-------------------|-------------------|-------------------|-------------------|

23. Хүннүтэй холбоотой гол үйл явдлыг түүнд хамаарах цаг хугацаатай нь зөв тохируулна уу?

- | | |
|--|--------------|
| 1. Хүннү Хань улсууд гэрээ байгуулж хилээ тогтоов. | А. НТ93 он |
| 2. Хүннү гүрэн байгуулагдав. Модун Хүннүгийн хаан болов. | Б. НТ48 он |
| 3. Хүннү улс умард өмнөд 2 хэсэгт хуваагдав. | В. НТӨ198 он |
| 4. Хүннү гүрэн мөхөв. | Г. НТӨ209 он |

24. Жужан улс нь 555 онд мөхжээ. Жужан улс мөхөхөд хүргэсэн шалтгаанд аль нь орохгүй вэ?

- А. Баруун болон Зүүн Вэй улсын хагалан бутаргах бодлого
- Б. Жужаны харъяат Уйгур, Теле аймгуудын бослого
- В. Жужаны харц ядуус бослого тэмцэл гаргасан.
- Г. Жужаны харъяат Алтайн Түрэгүүд бослого гаргасан

25. 745-840 оны хооронд Монгол нутагт төр улсаа байгуулж байсан Уйгур улсын оршин тогтнож байсан хугацааг зуун, мянганд зөв шилжүүлсэнийг олно уу.

- А. Хоёрдугаар мянганы VII зууны эхэн үеэс VIII зууны эхэн хагас
- Б. Нэгдүгээр мянганы VIII зууны дунд үеэс IX зууны дунд хагас
- В. Нэгдүгээр мянганы VI зууны дунд үеэс VII зууны дунд хагас
- Г. Хоёрдугаар мянганы IX зууны эхэн үеэс X зууны эхэн хагас

26. Дараах үйл явдлыг зөв дараалалд оруулсныг нь тэмдэглэ.

- А. Их Монгол улс байгуулагдсан
- Б. Монгол ханлиг улсууд бие даан оршиж байсан
- В. Чингис Хамаг Монголын хаан болсон

Г. Монголын эзэнт гүрэн байгуулагдсан

1. А, В, Г, Б

2. Б, В, А, Г

3. А, Б, В, Г

4. Г, А,Б, В

27. Чингис хаан 1204 онд Наймантай байлдахдаа ямар тактик хэрэглэж байсан бэ


А. Ялагдсан мэт зугатаж байгаад эргэж бүслэлтэнд оруулсан

Б. Зориуд туранхай агт олзлуулж дайснаа тайвшруулсан

В. 10 цэрэг дундаа нэг түүдэг асааж цэргийн хүчийг бага харагдуулсан

В. Боорчи, Борохул нараар цайзын хаалгыг онгойлгуулсан

28. Эдгээс аль нь XVII зууны эхэн үеийн Түшээт ханы нутаг вэ?



- А. 1
- Б. 2
- В. 3
- Г. 4

29. Лигдэн хааны дайчин төрөөр нэгтгэх бодлого явуулсны сөрөг үр дагавар юу вэ?

А. Халхын ноёдыг Манжид дагаар ороход хүргэжээ.

Б. Мин улсыг Манжтай холбоо тогтоон Лигдэний эсрэг тэмцэхэд хүргэжээ

В. Дотоодын хямралыг гүнзгийрүүлж, зарим ноёдыг Манжид дагаж ороход хүргэжээ.

Г. Цахар болон Ойрадын харилцааг хурцатгажээ.

30. 1640 онд Халх, Ойрад, Халимаг, Хошуудын нөлөө бүхий 28 ноёд Тарвагатай уулын Улаан бураа хэмээх газар чуулан “Их цааз”-ыг баталжээ. Энэхүү их цаазын ач холбогдол юу вэ?

А. Халх, Ойрад, Халимаг, Хошуудын нөлөө бүхий ноёдын нэгдсэн засгийн газар байгуулж, тархай бутархай байдлыг зогсоосон эрх зүйн баримт бичиг болсон.

В. Халх, Ойрад, Халимаг, Хошууд улсууд нэгдсэн нэг улс болж нэгэн хааны захиргаанд нэгдэхээр тохиролцсон эрх зүйн баримт бичиг болсон.

С. Халх, Ойрад, Халимаг, Хошууд улсууд нэгдэн Өвөрмонголыг манжийн эрхшээлээс гаргахаар тохиролцсон эрх зүйн баримт бичиг болсон.

Д. Хоорондоо эв эеэ сахих, шаардлагатай үед нэгдсэн хүчээр дайсныг сөрөн зогсох боломжийг бий болгосон эрх зүйн баримт бичиг болсон.

31. Адилтгах замаар асуултын тэмдгийн оронд тохирох үгийг дараах өгөгдлөөс сонгоно уу.

Палеолит – Агуй, овоохой Неолит- ?

А. Давхар сууц Б. Модон байшин В. Газар сууц Г. Өвсөн эмбүүл

32. Шинэ чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн хөдөлмөрийн хуваарьт гарсан өөрчлөлтийг баримтад үндэслэн тайлбарлаарай.

Хөдөлмөрийн хуваарь	
Эрэгтэй	Эмэгтэй
Давуу тал	Давуу тал

33. Монголын эртний улсуудыг цаг хугацааны хувьд зөв дараалалд оруулан ард нь цувруулан бичээрэй

1. Сяньби
2. Монгол татар
3. Түрэг
4. Хятан
5. Уйгур
6. Хүннү

34. Хүннүгийн дараах Монголын эртний улсуудыг түүхэн зүтгэлтнүүдтэй нь зөв харгалзуулан холбоорой

- | | |
|-----------|--------------|
| 1. Сяньби | А. Амбагян |
| 2. Жужан | Б. Моюнчур |
| 3. Түрэг | В. Мугулуй |
| 4. Уйгур | Г. Таншихуай |
| 5. Хятан | Д. Буман |

- | | | | |
|-----------------------|-----------------------|---------------------|-----------------------|
| 1. 1Г, 2В, 3Д, 4Б, 5А | 2. 1В, 2Г, 3А, 4Б, 5Д | 3. 1Д2А, 3Б, 4В, 5Г | 4. 1Г, 2Б, 3А, 4Д, 5В |
|-----------------------|-----------------------|---------------------|-----------------------|

35. Палеолит болон мезолитын үеийн чулуун зэвсгийн онцлогийг зурагт үндэслэн тайлбарлаарай.



Чулуун зэвсэг	Хэлбэр хийц	Зориулалт
Палеолит		
Мезолит		


36. Их монгол улс, монголын эзэнт гүрний хаадын төр барьсан хугацааг зөв тохируулаарай.

- | | | | |
|-----------------------|-----------------------|-----------------------|-----------------------|
| 1. Хубилай | а. 1206-1227 | | |
| 2. Чингис | д. 1260-1294 | | |
| 3. Мөнх | г. 1251-1259 | | |
| 4. Гүюг | б. 1229-1241 | | |
| 5. Өгөдэй | в. 1246-1248 | | |
| 1. 1В, 2А, 3Г, 4Б, 5Г | 2. 1А, 2Б, 3В, 4Г, 5Д | 3. 1Д, 2А, 3Г, 4В, 5Б | 4. 1Г, 2А, 3Б, 4Д, 5В |

37. Чингис хааны угсаа залгамжлагчдын эзэлсэн орнуудыг зөв тохируулаарай

- | | | |
|-----------------------|---|---------------|
| 1. Өгөдэй захируулав. | б 1230-1234 онд Алтан улсыг, Солонгосыг дайлан дагуулж даргач суулган | |
| 2. Гүюг | в б.1256 онд Сүн улсын олон боомтыг амжилттай байлдан дагуулж яваад 1259 оны зун нас баржээ | |
| 3. Мөнх | а. 1247 онд Сүн улсыг эзлэх дайныг эхлүүлэв. | |
| 1. 1А, 2В, 3Б | 2. 1Б, 2А, 3В | 3. 1В, 2Б, 3А |

38. Энэхүү бичээсийг ямар бичгээр бичсэн бэ?



- А. Али гали Б. Соёмбо В. Тод Г. Дөрвөлжин

39. Сурвалжуудыг нэрлээрэй.

.....



40. Алтан орд улсын газар нутгийг зөв тодорхойлно уу

А. Өнөөгийн Иран, Ирак, Солонгос, Хятадын нутаг

Б Или голын сав, Долоон гол, Кашгарын нутаг буюу Хуучин Хар Хятаны нутаг

В Өнөөгийн Иран, Ирак, Азербайжан, Армян, Гүрж, Турк, Сирийн хойд хэсэг Афганистаны баруун хэсэг

Г Монгол, Төвд, Солонгос, Хятадын нутаг

Д Дорно зүг Эрчис мөрөн, өрнө зүгт Дунай мөрний доод урсгал, өмнө зүгт Кавказын нуруу, хойд зүгт Ижил мөрөн хүртэл

